



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2015 оны 03 сарын 20 өдөр

Дугаар 135

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа,
үнийг шинэчлэн тогтоож, балансаас
балансад шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дугаар зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1, 5.6, 7.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Эрчим хүчний төсөл-2"-ийн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, 168,636,364.00 (нэг зуун жаран найман сая зургаан зуун гучин зургаан мянга гурван зуун жаран дөрөв) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий Тоёота Ландкрузер-200 маркийн, 27-68 УБК улсын дугаар, JTMHV05J804257650 арлын дугаартай тээврийн хэрэгслийн ашиглах хугацааг 8 жилээр сунгаж, нийт үнийг 28,000,000.00 (хорин найман сая) төгрөгөөр шинэчлэн тогтоож "Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ" төрийн өмчит хувьцаат компанид балансаас балансад шилжүүлсүгэй.

2. Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Тавинбэх, "Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ" төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Б.Дашдаваа нарт дор дурдсан арга хэмжээг авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгийн ашиглах хугацааг сунгах, үнийг шинэчлэн тогтоох, хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусгах;

2.3. Тээврийн хэрэгслийг татвар төлөгчийн бүртгэл, улсын бүртгэлээс шилжүүлж, арга хэмжээний биелэлтийг 2025 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх;

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Д.НАРАНГЭРЭЛ
132000313
7-r huraldaan.docx